ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 12 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар ..2.. | Улаанбаатар хот

"Жендэрийн Үндэсний
шинжээч-зөвлөх" бүлэг байгуулах тухай

Жендэрийн Үндэсний хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хурлаас ТОГТООХ нь:

НЭГ. Засгийн газрын 2013 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегид заасны дагуу Жендэрийн Үндэсний хорооны дэргэд зөвлөх үүрэг бүхий "Жендэрийн Үндэсний шинжээч-зөвлөх" бүлэг байгуулсугай.

ХОЁР. Жендэрийн Үндэсний шинжээч-зөвлөх бүлэг байгуулах ажлыг удирдан зохион байгуулж, холбогдох дүрэм журмыг батлах ажлыг Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /М.Болормаа/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА Н.АЛТАНХУЯГ

УЛААНБААТАР
ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ХОРОО
ТТА 747